



“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04-р сарын 19-ний өдөр

Дугаар 24/01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 14:00 цагт ХУД-ийн 2-р хороо Арьс ширний үйлдвэрийн хашаанд байрлах өөрийн байранд зохион байгуулагдав. Хурлыг Булигаар ХК-ийн ердийн гишүүн Б.Анхболд даргалж, Хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн хараат бус гишүүд, Сөрөлт дөл аудит ХХК-ийн төлөөлөгч нар оролцов.

ТУЗ-ийн гишүүн Ц.Мөнхлхагва: ТУЗ-ийн дарга А.Энхмэнд хүндэтгэх шалтгаанаар хуралд биечлэн оролцох боломжгүй болсон тул Б.Анхболд гишүүн хурлыг даргаар шийдвэрлэсэн байгаа.

Хурлын дарга Б.Анхболд: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд бэлэн боллоо. Хурлаа албан ёсоор эхлүүлэхээс өмнө хурлыг албажуулах ёстой бөгөөд Тооллогын комиссоос хурлын ирцийн мэдээллийг өгнө үү хэмээн хүсэж байна.

ХУРЛЫН ИРЦИЙГ ТАНИЛЦУУЛАХ:

Тооллогын комиссын дарга Ю.Дүгэрмаа: Булигаар ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг мэдээлье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөр тогтоосныг дурдъя.

Бүртгэлийн өдрөөр Булигаар ХК-ийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны тоо 400,212,000 ширхэг байснаас өнөөдрийн хурал биечлэн оролцох арга хэлбэрээр болон хурлын материалтай урьдчилан танилцан санал өгөх хэлбэрээр 156,630,000 саналын эрхтэй 1 хувьцаа эзэмшигч нийт 352,706,413 ширхэг саналын эрхтэй 6 хувьцаа эзэмшигч оролцсоноор нийт ирц **88.13%** болсноор Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлын ирц бүрдсэнийг мэдэгдэж байна.

ХУРЛЫН ДЭГИЙГ ТАНИЛЦУУЛАХ:

Хурлын дарга Б.Анхболд: Хурлын дэгийг товч танилцуулахад:

- Хэлэлцэх асуудлын дагуу илтгэлүүдийг та бүхэнд хүргэнэ.
- Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуултад хариулт явагдана.
- Санал хураалт явагдана.
- Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгээд үр дүнгээ танилцуулна.
- Хурлаас гарах шийдвэрүүдийг тогтоол болгож та бүхэнд танилцуулаад хурал албан ёсоор дуусах юм.

Хурлаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Бид энэхүү хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж, 3-н асуудал дээр санал авч шийдвэр гаргах байгаа. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох
3. ТУЗ-ийн цалин урамшуулал, зардлын төсөв танилцуулж, батлах тухай хэлэлцэн санал хураалтаар шийдвэр гарна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУДЫГ ТАНИЛЦУУЛАХ:

Нэг. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах.

Гүйцэтгэх захирал Б.Анхболд: 2024 он гараад манай компанийн 90 жилийн ой болсон. Мөн Монгол Улсад Хөнгөн аж үйлдвэрийн салбар үүсэж хөгжсөний 90 жилийн ойтой давхцаад арьс ширний салбар, ноос ноолуурын нэгдлүүдтэй хамтраад сая дөнгөж тэмдэглэж өнгөрснийг дуулгахад таатай байна.

За 2023 оны хувьд Булигаар ХК нь анх төлөвлөж төсөөлсөн хэмжээнээсээ борлуулалтын дүн буурсан байгаа үүний шалтгаан нь хэд хэдэн үндсэн шалтгаантай байгаа 1 дэх өнгөрсөн онд НӨАТ-тай 8 тэрбум, НӨАТ-гүй 7.2 тэрбум борлуулалт хийсэн нь өмнөх онхоос 16 хувиар борлуулалтын орлого буурч, улмаар 429 сая гаруй төгрөгийн цэвэр ашигтай байж байгаад 68 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Энд хэд хэдэн шалтгаан нөхцөл байгаагаас хамгийн түрүүнд дэлхийн зах зээл дээр боловсруулсан арьсны үнэ өндөр сайн байгаагүйтэй холбоотойгоор дотоод борлуулалт буурсан. Үүнийг дагаад түүхий эдийн үнэ буурахаар холын аймгуудаас ирдэг үхрийн ширний тоо хэмжээ багасаад түүхий эдээ бид хангалттай сайн татаж авч чадсангүй. Гол нь чанарын асуудал дордсон шалтгаан нь хөдөө орон нутагт малчид хотондоо гаргаж байгаа арьс шир нь харьцангуй эсгэлт зүсэлт багатай байдаг бол энэ нь холын аймгуудаас малчдаас түүхий эд нь ирэх нь багасаж, энэ ойрхон УБ хотыг тойрсон гар бойнууд, махны үйлдвэрүүдийн арьсаа бэлтгэхдээ цоолдог асуудал нь асар их, улам бүр нэмэгдсэн байгаа. Хуучин бид 1000 арьсан тутам 800 гаруй арьсыг эцсийн бүтээгдэхүүн болгоод боловсруулдаг байсан бол энэ хэмжээ 60 хувь хүртэл унасан. Режек /гологдол/ гэж бид нар ярьдаг ашиглалтад тэнцэхгүй болсон арьс маш их ирж байгаа үүнээс болоод үйлдвэрлэл болон борлуулалтын хэмжээ багассан харагдаж байгаа. 2 дахь шалтгаан нь 2022 оны 2-р сараас БНХАУ хилээ нээсэн. БНХАУ хилээ нээснээс ковидын үед Хятад дотооддоо нэлээн үйлдвэрлэгдсэн байсан боловсруулсан арьс хил хаагдсан үед экспортолж чадаагүй хуримтлагдсан байсан арьснууд манай дотоод зах зээл дээр их хэмжээгээр орж ирээд дотоод үйлдвэрлэгч нарт тэр арьс нийлүүлэгдсэнээс шалтгаалан борлуулалтын хэмжээнд нөлөөллөө. 3 дахь нь бидний арьсыг авч хэрэглэдэг бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хувьд гаднаас бэлэн бүтээгдэхүүн их хэмжээгээр орж ирснээс тэдний борлуулалт эрэлт хэрэгцээ буурсан үндсэндээ ийм 3 шалтгаанаас өнгөрсөн онд манай төлөвлөж байсан 11 тэрбум төгрөгд хүрээгүй. Санхүүгийн хувьд нийтдээ 7.2 тэрбумын борлуулалт хийж, 68 сая төгрөгийн ашиг оллоо. Нийт хөрөнгийн хувьд 2023 оны жилийн эцсийн балансаар 33.9 тэрбумын хөрөнгөтэй, үүнээс мөнгөн гүйлгээ нь 6.6 тэрбум төгрөг байсан байна. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувьд 247,888 ширхэг ямааны, 92,094 ширхэг өрөөл үхрийн арьс боловсруулсан бөгөөд 2022 онд үхрийн өрөөл арьсны дундаж хэмжээ 107 дм.кв байсан бол 2023 онд дундаж нь 122.9 дм.кв болж нэмэгдсэн ингэснээр нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 2022 онд 15,074,312 дм.кв байсан бол 2023 онд 11,318,249 дм.кв болсон.

2021 оноос эхлэн гадаад зах зээл рүү борлуулалт хийж эхэлснээр ба тухайн онд нийт борлуулалтын 8.6%-ийг эзэлж байсан бол 2022 онд нийт борлуулалтын 21%-ийг, 2023 онд нийт борлуулалтын 19%-ийг гадаад борлуулалт бүрдүүлэх болсон.

Өнгөрсөн онд гадаад борлуулалт нөлөөлөх том алхам хийсэн байгаа энэ нь Олон улсын арьс ширний групп болох Leather Working Group байгууллагаас LWG гэсэн чанарын гэрчилгээ авч чадсан байгаа. Энэхүү гэрчилгээ авч чадсанаар гадаад борлуулалт ялангуяа гүйцэд боловсруулсан үхрийн арьс экспортлох боломжтой гэж харьж байгаа. Өнгөрсөн жилийн хувьд нийт борлуулалтын 19% нь гадаад борлуулалт, 81 хувь нь дотоод зах зээлд боловсруулсан байна. 2023 онд хөрөнгө оруулалтаар нийт 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 46.8 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 42.2 хувийг төгрөгийг барилга байгууламжийн бүтээн байгуулалт, 11% хувийг бусад хөрөнгө оруулалтад зарцуулсан байна.

Тухайлбал, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн хувьд нэг дор 1000 үхрийн өрөөл арьс хатаах хүчин чадалтай гинжин хатаалгад 31,669,899 төг, хромын 2 барабан байсныг тоноглол хийж будгийн барабан болгосон. Ингэснээр өдөрт 1000 өрөөл арьс будах хүчин чадалтай болсон. Будгийн барабаны тоноглолд 24,974,602 төгрөг тус тус зарцуулсан.

За түрүү дурдсан LWG гээд гэрчилгээ авсан. “Булигаар” ХК нь байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах, хэрэглэгчдийн шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүнийг хүргэх зорилгоор 2023 оны 1 дүгээр улирлаас эхлүүлэн үйл ажиллагаандаа олон улсын LWG стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн билээ. Бид 2023 оноос эхлэн LWG хэрэгжүүлэх төслийн багийг байгуулан стандартыг үе шаттай нэвтрүүлэх төлөвлөгөө гаргаж ажилласан ба 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Олон улсын “Leather Working Group”-аас “Булигаар” ХК-ийн үйл ажиллагаанд аудит хийж, тохирлын үнэлгээ, хяналт шинжилгээгээр олон улсын LWG стандартын шаардлагыг бүрэн хангасан тул ийнхүү баталгаажуулалтын гэрчилгээг авсан. Энэхүү гэрчилгээг авахын тулд 16 протокол үндсэн шаардлага байдаг энэ шаардлагыг хангасан компаниудад энэхүү гэрчилгээг өгдөг. Европын ихэнх брэндүүд, зарим компаниуд ийм гэрчилгээтэй арьсыг худалдаж авахаар өөрсдөө шаардлага тавьсан байдаг. Тэгэхээр бидний хувьд европын зах зээлд гарах түншүүдтэй болох боломж нээгдэж байна. Энэхүү гэрчилгээний үндсэн дээр бид өнгөрсөн онд хавар, намар Итали улсын Милан хотноо зохиогддог Lineapelle үзэсгэлэнд оролцсон. Тодорхой хэмжээний түншүүдээ нэмэгдүүлэн захиалга туршилтын ажил эхэлсэн явж байгаа, мөн компанийн техник, технологийн баг хамт олон БНХАУ-ын Шанхай хотод зохион байгуулагдсан арьс, ширний үзэсгэлэнд оролцож тоног төхөөрөмж, технологийн талаар судалгаа хийж, зарим химийн материалын компаниудтай харилцаа тогтоосон байгаа.

Хоёр. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг танилцуулах

2024 онд хийгдэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын хувьд 591 сая төгрөг засвар үйлчилгээний ажил хийхээр төсөвлөснөөс цэвэрлэх байгууламж 20 сая, тоног төхөөрөмж 340 сая төгрөг шахах машин авахаар, урсгал их засварт 200 сая төгрөг төсөвлөсөн байна. Өнгөрсөн жил химийн материалд 2 тэрбум төгрөгийн материал гадаадаа татаж авсан бол энэ жил 3.5 тэрбум химийн материал татаж авахаар төлөвлөөд ажиллаж байна. Мөн 100 мянган үхрийн шир худалдан авч эцэслэн боловсруулахаар дотоод гадаадын зах зээлд худалдахаар төлөвлөөд байна.

2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу төсөвлөсөн нийт зардлын дүн урьдчилсан байдлаар 14 тэрбум 870 сая төгрөгийн зардал гарахаар төлөвлөсөн бөгөөд үүнээс үндсэн хөрөнгөд 591 сая, зээл болон зээлийн хүүний төлбөрт 4.7 тэрбум шахагдаад тулаад байгаа түрүү авсан зээлүүд төлөгдөөд 4.7 тэрбум үлдээд байгаа үүний хугацаа дуусаж байгаа дахин санхүүжүүлэх тооцоотой ажиллаж байгаа, үйл ажиллагааны зардалд 9.5 тэрбум төгрөг гэсэн байгаа бөгөөд задаргаа нь дараагийн хуудсанд дэлгэрэнгүй байгаа.

2024 онд нийт 100,000 үхрийн ширийг гүн боловсруулж, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн эрэлтэд голлох 3 төрлийн артикл буюу хэв шинжтэйгээр үйлдвэрлэн худалдаалахаар төлөвлөж байна. Үүнд үхрийн хром, булигаар, ажлын гутлын артай хром нэр төрөл орно. Үхрийн ширний борлуулалтын орлого нийт 11 тэрбум төгрөг, 15 мянга дм арьс боловсруулна гэсэн урьдчилан төлөвлөж байна. Үүнээс ямааны арьс нь гутлын дотор хийгдэх гол үндсэн түүхий эд болдог ба бид ямааны вет-блю болон краст арьсыг гадагшаа экспортод гаргадаг. 2024 онд урьдчилсан тооцооллоор ямааны краст 100,000 ширхэг, нэгжийн үнэ \$3, ямааны вет-блю 180,000 ширхэг нэгжийн үнэ \$1.8-р экспортолж, нийт 2.6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлогын прогнозтай байна. Түрүү дурдсан үйл ажиллагаатай холбоотой зардал 9.5 тэрбум гарна. 4.7 тэрбум төгрөгийн тодорхой хэмжээг нь төлөөд үлдсэн нь банк санхүүгийн байгууллагуудтай харилцаж дахин санхүүжүүлэх төлөвлөгөөтэй ажиллахаар зорьж байгаа.

Гурав. Компанийн 2022 оны ногдол ашиг тараалт

Компанийн ТУЗ-ийн 2023.02.15-ны өдрийн 03 тоот тогтоолоо нэгж хувьцаанд 0.25 төгрөг хуваарилахаар шийдвэр гаргасан. Ногдол ашгийг 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгож 2023 оны 09 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”-өөр дамжуулан олгохоор ногдол ашиг зуучлуулан тараах гэрээний дагуу нийт 787 хувьцаа эзэмшигчийн дансанд 400,212,000 ширхэг хувьцаанд ногдох 100,053,000 төгрөгийг байршуулан бүрэн олгосон.

Дөрөв. 2023 онд ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн гаргасан тогтоолыг танилцуулах

ТУЗ-ийн гишүүн Ц.Мөнхлхагва: Булигаар ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024.02.16-ны өдрийн 03/24 тоот Ногдол ашгийн тухай тогтоол гарсан бөгөөд уг тогтоолын 1-д “Булигаар” ХК-ийн 2023 оны санхүүгийн жилийн ашигт ажиллагаа зорилтод түвшинд хүрээгүй, ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадамжтай байх гэсэн Булигаар ХК-ийн ногдол ашгийн бодлогын 2.2 дахь хэсгийн 2.2.1 дэх заалтыг хангаагүй гэх үндэслэлүүдээр Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2-т Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг ТУЗ-д даалгасугай.

Ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг тарааж өгсөн материалаас танилцах боломжтой байгаа.

Тав. ТУЗ-ийн үйл ажиллагааны товч тайланг танилцуулах

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Эрдэнэбат: Бүгд нь энэ өдрийн мэнд хүргэе. Булигаар ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 онд нийтдээ 7 удаагийн хуралдаанаар 8-9 хүний ирцтэйгээр 10 тогтоол, 7 тэмдэглэл гаргаад гүйцэтгэх удирдлагад хэрэгжүүлэхийг даалгасан. 2023 оны төсвөө 81 хувийн гүйцэтгэлтэй зарцуулсан. Төсвийн гүйцэтгэлийг эндээс дэлгэрэнгүй харж болно. 2024 оны төсвөө 16.6 сая төгрөгөөс төсөвлөж оруулж байгаа. ТУЗ-ийн хараат бус гишүүний цалин жилд 10 давтамжтайгаар 250,000 төгрөгийг олгохоор нийтдээ жилд 7.5 сая төгрөг, Бичиг хэрэг, хурлын зардалд 9.1 сая төгрөгийг төсөвлөсөн байна. Энэхүү зардлын хувьд МХБ болон ҮЦТХТ-ийн үйлчилгээний хураамж, бичиг хэрэг, цай кофе, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зардал багтсан байгаа.

Дэлгэцээр төсвийн дэлгэрэнгүй харуулж байна. Энэ удаагийн ХЭЭХ-аар хэлэлцэж батлуулна.

Зургаа. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Эрдэнэбат: Булигаар ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Компанийн тухай хууль, Булигаар ХК-ийн дүрмийн холбогдох заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна. Ерөнхийдөө компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс сайжруулах шаардлагатай. Зорилтод төлөвлөгөө биелүүлээгүй, түрүү Анхболд захирал хэлсэн. 2023 онд Монгол Улсын хууль эрх зүй болон бизнесийн орчинд тохируулан үйл ажиллагаа явуулсан хамгийн бол нь тооцоолоогүй эрсдэл, нөхцөл байдал нь борлуулалтад нөлөөлж төлөвлөгөө тасарсан. Үүнтэй холбоотойгоор үйл ажиллагаа сайжруулах хэрэгтэй гэж дүгнэсэн. Мөн санхүүгийн тайланд сайжруулах шаардлагатай гэж дүгнэлт өгсөн хамгийн гол нь хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлууд хийгдэх ёстойгоор гүйцэтгэсэн. Борлуулалтаас хамаарч борлуулалтын орлого тасалдсан үүнээс хамаарч үйл ажиллагаа жаахан доголдоноос эзэмшигчдийн өмч 11.7 тэрбум байж байгаад жаахан буурсан үзүүлэлттэй гарсан. Үүнийг дараагийн шинээр байгуулагдах ТУЗ-өөр авах хэмжээг хэлэлцэхээр шийдвэрлэсэн. Санхүүгийн тоон мэдээллээс тодруулж асуувал мэдээлэл өгөх хүмүүс нь байгаа ТУЗ-ийн хараат бус гишүүд, мөн санхүүгийн тайланд аудит хийсэн хараат бус Сэрэлт дөл аудит ХХК-иас ирсэн байгаа.

Хувьцаа эзэмшигч П.Нямдорж: Тарааж өгсөн материалд байгаа гээд энэ дээр байхгүй байна. Эсвэл өөр материал байгаа уу? Б.Анхболд захирлын түрүү ярьсан төлөвлөгөө.

Хурлын дарга Б.Анхболд: Нарийвчлаад дэлгэцээр үзүүлсэн үү? 2024 оны төлөвлөгөө хэвлээд өгье.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Эрдэнэбат: 2024 оны төлөвлөгөөнүүд ороогүй байх. Тарааж өгсөн материалд гүйцэтгэлүүд нь орсон байгаа.

Хувьцаа эзэмшигч П.Нямдорж: Санхүүгийн тайлан, нэр дэвшигчдийн танилцуулга, тогтоолын төсөл, ТУЗ-ийн дүгнэлт нь алга?

ТУЗ-ийн гишүүн Ц.Мөнхлхагва: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тараах материалын 8,9-р хуудас дээр дэлгэрэнгүй байгаа.

Хувьцаа эзэмшигч П.Нямдорж: Тийм байна.

Булигаар ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт:

Булигаар ХК нь 2023 онд 11 тэрбум төгрөгийн борлуулалтын төлөвлөгөөтэй ажилласан бол бодит гүйцэтгэлээр 7,206.9 сая төгрөгийн борлуулалт хийж, борлуулалтын төлөвлөгөө 65 хувийн биелэлтэй ажиллаж, өмнөх оноос 16 хувиар буурсан байна.

2023 онд нийт 299 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 17.4 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 29.4 хувийг тоног төхөөрөмжийн урсгал засвар, 38.1 хувийг барилга байгууламжийн бүтээн байгуулалт, 11% хувийг бусад хөрөнгө оруулалтад зарцуулсан байна.

Тус компани өнгөрсөн онд нийтдээ 8,537,653,532.34 төгрөгийн орлого олсон. Тайлант хугацаанд өнгөрсөн оныхоос 1,330,700,714.30 төгрөгөөр борлуулалт буурсан байна. Тайлант хугацаанд 1,729,082,097.95 төгрөгийн үйл ажиллагааны зардал гарсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 192,297,580.08 төгрөгөөр өссөн бөгөөд үүнээс үйл ажиллагааны зардлын 722,300,315 төгрөгийг ашиглалтад, 88,221,606 төгрөгийг урсгал засвар хийхэд, 728,107,632 төгрөгийг зээлийн хүүгийн зардалд зарцуулсан байна.

Тайлант үеийн жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгийн дүн 33,957,389,082.25 төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 45.4 хувь буюу 15,416,088,640.32 төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 54.6 хувь буюу 18,541,300,441.93 төгрөгийг эзэлж байна.

Эргэлтийн хөрөнгийн 0.14 хувь буюу 22,914,287.62 төгрөгийг мөнгө, авлага зэрэг түргэн хөрвөх хөрөнгө, 61.26 хувь буюу 9,445,382,624.47 төгрөг бараа материалд, 32.5 хувь буюу 5,015,778,458.74 төгрөг урьдчилж төлөгдсөн зардалд 6.04 хувь буюу 932,013,269.49 төгрөг эзэлж байна. Эргэлтийн бус хөрөнгийн дийлэнх хувь болох 95.1 хувь буюу 17,641,055,093.24 төгрөгийг үндсэн хөрөнгө болох барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, 1.9 хувь буюу 359,473,988.31 төгрөгийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Өр төлбөр ба Эзэмшигчдийн өмчийн хувьд бусдад төлөх өр төлбөрийн хэмжээ 22,294,624,890.31 төгрөг, эзэмшигчдийн өмчийн дүн 11,662,764,191.94 төгрөг байна. Нийт өр төлбөрийн 26.4 хувь буюу 5,893,279,577.17 төгрөгийг богино хугацаат өр төлбөр, 73.6 хувь буюу 16,401,345,313.14 төгрөгийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна. Эзэмшигчдийн өмч оны эхэнд 11,727,544,902.86 төгрөг байсан бол оны эцэст 11,662,764,191.94 төгрөг болж буурсан.

Гүйцэтгэх удирдлагын баг 2023 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглаж, хэтийн зорилгодоо хүрэх, компанийн хөгжлийг урагшлуулах алхмуудыг хийж, бизнесийн орчны өнөөгийн хууль эрх зүйн хүрээнд зах зээлийн байдалд зохицсон үйл ажиллагааг явуулж ажилласан байна.

Иймд “Булигаар” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс 2023 оны компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд **“сайжруулах шаардлагатай”** гэсэн дүгнэлт өгч байна.

Долоо. Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах

Сэрэлт дөл аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн амрыг ирье. Манай компани нь үйл ажиллагаа явуулаад 10 жил болж байгаа бөгөөд тусгай зөвшөөрөлтэй компани байгаа. Бид МУ-ын Аудитын тухай хуулийн 10.1 болон Нягтлан бодох бүртгэлийн 4.1.1, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд заасны дагуу хувьцаат компанийн аудит хийхдээ хувьцаат компанийн ТУЗ-өөс үнийн санал авсны дагуу саналаа өгч түүнд шалгарч гэрээ хийж хараат бус аудитын дүгнэлтээ гаргасан байгаа. Бид хараат бус аудитын дүгнэлтийг гарахдаа 2023.12.31-ний өдрийн байдлаар санхүүгийн үйл ажиллагаанд нь аудитын үйл ажиллагаа явуулсан. Аудитын үйл ажиллагаа явуулахдаа нэгэн гол анхаарах зүйл нь 2023 оны Булигаар ХК-ийн санхүүд материаллаг буруу илэрхийлэх, зайлан юм уу, үйл ажиллагааг буруу хандуулсан, санаатай буруу үйлдэл гаргасан, хөрөнгийг буруу ашигласан зэрэг үйл явдал байна уу зэрэгт гол анхаарал хандуулан ажилласан байгаа. Тэгээд хараат бус аудитын тайланг хийхдээ шинжилгээ дүгнэлт гаргасан. Мөн горим хэрэгжүүлж ажилласан. Тэгээд бидний дүгнэлтээр “Булигаар ХК-ийн 2023 оны жилийн санхүүгийн тайлангийн үйл ажиллагаанд ямар нэгэн залилан, бусдыг хохироосон, үндэслэлгүй үйл ажиллагаа явуулж нягтлан бодох бүртгэлийг будилаантуулсан гэсэн материаллаг зөрчил байхгүй байсан учраас бидний зүгээс санхүүгийн тайлангийн аудитыг зөрчилгүй гэсэн дүгнэлт гаргасан байгаа. Бид Булигаар ХК-ийн 2023 оны санхүү тайлангийн гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлан гүйцэтгэлтэй холбоотой зохих байгууллагаас гарсан дүрэм, журам, хууль дүрмийг мөрдөөгүй, түүнийг зөрчсөн гэсэн ямар нэгэн зөрчил илрээгүй учраас бид нар тайланг зөрчилгүй байна гэж үзсэн.

Аудитын дэлгэрэнгүйг дүгнэлтийг тарааж өгсөн материалаас танилцах боломжтой байгаа.

Хувьцаа эзэмшигч Б.Ганболд: Хөрөнгө дээр өнгөрсөн онд дуусаагүй барилга 500 байсан. Дуусгаад үндсэн хөрөнгө дээр шилжээд авсан юм уу? Эсвэл дахин дуусгаагүй юм уу?, акталсан юм уу?

Ерөнхий нягтлан бодогч Г.Оюунгэрэл: Хөрөнгийн акталсан ч юм уу данснаас хассан зүйл байхгүй. Дуусаагүй барилгыг үндсэн хөрөнгө руу шилжүүлээгүй байгаа. Сая e-balans шинэчлэгдсэн /санхүү байдлын тайлангийн систем/ систем дээр өөрчлөлт гарсантай холбогдуулаад дуусаагүй барилга гэсэн тодруулга тайланд бүртгэсэн маань эх тайлан санхүү байдлын тайланд татагдахдаа үндсэн хөрөнгө гэсэн цэс руу татагдаад тэрнээс биш дуусаагүй барилга гэснийг хөрөнгө рүү шилжүүлээгүй албан ёсоор барилгаа маань дуусаагүй. Шинэчлэгдсэн системийн дагуу алдаа илэрсэн юм.

Хувьцаа эзэмшигч Б.Ганболд: Барилга нь хаана байгаа юм химийн байгууламж юм уу?

Ерөнхий нягтлан бодогч Г.Оюунгэрэл: Цэвэрлэх байгууламж, тэр нь дуусаагүй барилга юм.

Хувьцаа эзэмшигч Б.Ганболд: Бусад урт хугацаат өр төлбөрүүд гээд 11 тэрбум төгрөг байна. Энэ юу билээ?

Ерөнхий нягтлан бодогч Г.Оюунгэрэл: Энэ анх 2019 онд хүлээн авахад нэлээн хэцүү байсан үед оруулсан хөрөнгө оруулалт байж байгаа юм.

Хурлын дарга Б.Анхболд: 2019 онд анх хяналтын багцыг аваад үйл ажиллагаа явуулж байхад цэвэрлэх байгууламж, нойтон цех нь ашиглалтад ороогүй байх үед Дархан минж ХХК-иас хагас боловсруулсан арьс нэлээн их авч байсан юм. Тэрний өр төлбөр байгаа дээрээс нь барилга байгууламж, тоног төхөөрөмжтэй холбоотой 3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Барилга байгууламжийн засвар, дотор халаалт, усны шугам

хоолойн дэд бүтэц, тоног төхөөрөмжийн шинэчлэлт, засварт орсон мөнгө байгаа. Буцаагаад Дархан минж ХХК руу 6 тэрбум төгрөгийн арьс худалдсан шилжүүлсэн тооцоо байгаа. Энэ хоёр хасагдалт энэ оны баланс дээр бичигдэхээр энэ өр багасаад орж ирнэ.

Цэвэрлэх байгууламжийн хувьд усаа цэвэрлээд явж байгаа боловч бүр төгс хараахан болоогүй байгаа нэмж хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээ, зарим тоног төхөөрөмжийг өөрчлөлт асуудал гараад байгаа. Энэ дээр эцсийн вариантаар дуусгаад хөрөнгө болгож авъя гэж хүлээж байгаа болохоор ийм бүртгэлээр явж байгаа. Урд нь арьсны үйлдвэрүүдийн бохирыг Харгиа гээд урьдчилан цэвэрлэх байгууламж хүлээн аваад цэвэрлэдэг анхны зохион байгуулсан бүтэц нь тийм байсан юм. Одоо тоног төхөөрөмж нь хуучирч муудаад цэвэрлэж чадахгүй дамжуулан урсдаг болсон. Тэгээд УСУГ-аас төв цэвэрлэх байгууламж руу бохир ус нийлүүлэхдээ заавал үйлдвэрүүд өөрсдөө урьдчилан цэвэрлэх байгууламж байх шаардлага тавьж байгаа. УБ хотын ус хангамжийн сайжруулах Мянганы сорилтын сан хүрээнд ус бохирдуулагч ус ашигладаг байгууллагуудын заавал өөрсдийн цэвэрлэх байгууламжтай байж үйл ажиллагаа явуулах шаардлага тавьж байгаа үүнийг дагуу 2021-2022 онд цэвэрлэх байгууламжийг гаднаа барьж ашиглалтад оруулаад явж байгаа. Мах, ноос, арьс, хүнсний үйлдвэрүүдээс 6 төрлийн бохир ус гардаг үйлдвэрийн стандартыг шинэчлэн гаргахаар болсон тэрэнд үндэслэн бидний зүгээс цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг түр хүлээгээд байгаа.

Хувьцаа эзэмшигч Б.Ганболд: Үйлдвэрүүдийг нүүлгэх асуудал дээр ямар нэг шийдэл гарсан уу?

Хурлын дарга Б.Анхболд: Үйлдвэрүүдийг хотоос нүүлгэнэ гэсэн шийдвэр нь 2012 онд гарсан. УИХ-ийн 74-р тогтоол гэж гарсан юм. Хамгийн гол нь нүүлгэе гэхээр Эмээлт нүүлгэх гээд байгаа. Эмээлт гэж байсныг Дархан руу гээд нэг хэсэг тодорхойгүй болгоод сүүлд харин Дэлхий банкны санхүүжилтээр Эмээлт рүү нүүлгэхээр болсон. Эмээлт рүү нүүлгэх гээд ТЭЗҮ хийгдэж байгаа гэсэн. ТЭЗҮ-ийн дагуу тэнд дулааны узель, цахилгааны дэд станц, цэвэрлэх байгууламж, ус хангамжийн систем баригдах юм байна лээ. Бэлэн болохоор нүүлгэх юм байна лээ. Бидний зүгээс хурдан нүүх юм сан гэж бодолтой байна. Энэ үйлдвэр хуучин 450 мянган үхрийн шир боловсруулах чадалтай, МУ-ын соц үед 1976 онд байгуулагдсан маш зардалтай үйлдвэр болоод байна. 400 гаруй мянган арьс боловсруулах чадалтай үйлдвэрт өнөөдөр бид 100 мянган арьс боловсруулна гээд төлөвлөгөө тавиад ажиллаж байж байна. Тэгэхээр үйлдвэрийнхээ хэмжээнд таарсан цомхон байр талбайтай шинэ цагийн шинэ технологийн дагуу төлөвлөлттэй болчихвол үйлдвэрийн зардал хүртэл багасаад ашигтай ажиллах боломж нь нэмэгдэх юм. Тэгээд энэ барилга түрээсэлбэл компанийн орлого хүртэл нэмэгдэнэ. Эмээлт нүүх ажил нэлээн идэвхтэй байгаа.

Найм. Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга.

Хурлын дарга Б.Анхболд: Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдээ түрүү жилийн сонгогдсон ТУЗ-ийн гишүүдээ үргэлжлүүлэн сунгаад ажиллуулъя гээд санал оруулж байгаа юмаа. Тарааж өгсөн материалд нэр дэвшигчдийн анкет танилцуулгыг оруулсан байгаа. Эдгээр нэр дэвшигчдээс асуух зүйл байна уу.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид

1. Жадамба овогтой Эрдэнэбат
2. Төмөрбаатар овогтой Болд
3. Чулуунбаатар овогтой Нямдорж

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчид

4. Батчулуун овогтой Анхболд
5. Батчулуун овогтой Баянжаргал
6. Анхболд овогтой Энхмэнд
7. Довжид овогтой Гансүх
8. Бямбабаяр овогтой Баттүшиг
9. Цэрэндагва овогтой Мөнхлхагва эдгээр хүмүүс нэр дэвшиж байна.

Хувьцаа эзэмшигч П.Нямдорж: Төлөөлөн Удирдах зөвлөлд нэр дэвших хүн олдсонгүй юу эсвэл энэ бүрэлдэхүүнээр ороод ирсэн үү?

ТУЗ-ийн гишүүн Ц.Мөнхлхагва: Нэр дэвшүүлэхээр хүсэлт ирүүлсэн хүн байхгүй байсан.

Хувьцаа эзэмшигч П.Нямдорж: Үйлдвэртэй танилцаж болох уу?

Хурлын дарга Б.Анхболд: Завсарлагааны цагаар болно.

САНАЛ ХУРААЛТ:

Санал хураалт 5 минут үргэлжлэв. 10 минут түр завсарлав. Тооллогын комисс саналыг хураалтын дүнг нэгтгэв.

САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ:

Тооллогын комиссын дарга Ю.Дүгэрмаа: Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал асуулгын тооллогын дүнг танилцуулахад бэлэн боллоо. Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя.

Санал хураалтын дүнгийн тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь заалт, Булигаар ХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг нэгтгэн тоолсныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Санал хураалтаар 88.13 хувийн саналын эрхтэй 352,706,413 ширхэг хувьцааны 6 ширхэг саналын хуудас хураасныг тооцсугай.

Хоёр. Компанийн байранд 39.14 хувийн саналын эрхтэй 156,630,000 ширхэг хувьцааны 1 ширхэг саналын хуудас ирүүлснийг дурдсугай.

Гурав. Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн олонхоор буюу 100% хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн саналын тоо					
Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,706,313	99.99997%	0	0%	100	0.00002%

Дөрөв. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин урамшуулал, зардлын төсөв батлах тухай хэлэлцэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн олонхоор буюу 100% хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн саналын тоо					
Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
352,706,413	100%	0	0%	0	0%

Тав. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудлыг кумулятив аргаар 352,706,413 ширхэг хувьцаатай 6 хувьцаа эзэмшигч саналаар дараах нэр дэвшигчид нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд сонгогдсоныг мэдэгдсүгэй.

Ердийн гишүүдэд:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Батчулууны Анхболд	88.11%	352,626,010
2	Анхболдын Энхмэнд	88.29%	353,348,737
3	Батчулууны Баянжаргал	88.11%	352,626,010
4	Довжидын Гансүх	88.11%	352,626,010
5	Бямбабаярын Баттүшиг	88.11%	352,626,010
6	Цэрэндагвын Мөнхлхагва	88.11%	352,626,010

Хараат бус гишүүдэд:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Жадамбын Эрдэнэбат	88.11%	352,626,310
2	Төмөрбаатарын Болд	88.11%	352,626,310
3	Чулуунбаатарын Нямдорж	88.11%	352,626,310

Тооллогын комиссын дарга Ю.Дүгэрмаа

Тооллогын комиссын гишүүд Д.Энхзул, Б.Саруул

ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫГ ТАНИЛЦУУЛАХ:

Хурлын дарга Б.Анхболд танилцуулав.

**Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагаа
болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн
дүгнэлтийг батлах тухай**

МУ-ын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Булигаар ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. “Булигаар” Хувьцаат компанийн 2023 оны жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Нэгдүгээр хавсралт ёсоор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА Б.АНХБОЛД

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

МУ-ын Компанийн тухай хуулийн 62 дүгээр зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 24/01НДХ дүгээр тогтоол, Булигаар ХК-ийн 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. “Булигаар” Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Жадамбын Эрдэнэбат

Төмөрбаатарын Болд

Чулуунбаатарын Нямдорж

Төлөөлөн Удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:

Батчулууны Анхболд

Анхболдын Энхмэнд

Батчулууны Баянжаргал

Довжидын Гансүх

Бямбабаярын Баттүшиг

Цэрэндагвын Мөнхлхагва

Хоёр. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм журмын дагуу ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Б.АНХБОЛД

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны зардлын төсөв батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дүгээр зүйлийн 62.1.13 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны 24/01 ЦУХ тоот тогтоол, Булигаар ХК-ийн 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Нэг. Булигаар ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны зардлын төсвийг Нэгдүгээр хавсралтад зааснаар баталсугай.

Хоёр. Баталсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, цалин хөлс, урамшууллыг үр дүн харгалзаж олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Б.АНХБОЛД

Булигаар ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн
..... тоот тогтоолын Нэгдүгээр хавсралт

ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв

Д/д	Зардлын нэр	Тоо	Давтамж	Нэгж зардал	Дүн
Цалин, урамшууллын зардал					
1	ТУЗ-ийн ердийн гишүүний цалин	6	10		-
2	ТУЗ-ийн хараат бус гишүүнийн цалин	3	10	250,000	7,500,000
3	ТУЗ-ийн нарийн бичиг	1	12		-
	Хэсгийн дүн				7,500,000
Бичиг хэрэг, хурлын зардал					
1	МХБ-ийн үйлчилгээний хураамж	1	1	500,000	500,000
2	ҮЦТХТ ХХК-д хувьцааны хадгаламжийн хөлс	1	1	500,000	500,000
3	ҮЦТХТ ХХК-д ногдол ашиг тараалгах хураамж				-
4	Санхүүгийн тайланд аудит хийх ажлын хөлс	1	1	6,000,000	6,000,000
6	ҮЦТХТ ХХК-д тархалтын мэдээ	1	1	121,700	121,700
7	ХЭ-ийн хурлын зар өгөх	2	2	200,000	800,000
8	Хурлын материал бэлтгэх зардал	1	1	300,000	300,000
9	ХЭ-д өгөх гарын бэлэг	20	1	30,000	600,000
10	Бичиг хэрэг, цай кофены зардал	1	1	300,000	300,000
	Хэсгийн дүн				9,121,700
	НИЙТ ДҮН				16,621,700

Хурлын дарга Б.Анхболд: Булигаар ХК-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үүгээр өндөрлөж байна. Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа

Хурал 15 цаг 20 минутад өндөрлөв.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ:

Б.АНХБОЛД

Хурлын тэмдэглэл хөтөлсөн.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН ДАРГА:

Ц.МӨНХЛХАГВА

